ХӨВСГӨЛ АЙМГИЙН ЭРҮҮЛ МЭНДИЙН ГАЗАР
УЛСЫН БАЙЦААГЧИЙН ДҮГНЭЛТ

Эрүүл мэндийн газрын байр, 8 дугаар баг,
Мөрөн сум, Хөвсгөл аймаг, 67120
Утас: 7038 2496, Цахим шуудан: emg@khs.gov.mn
Цахим хуудас: khs.mohs.gov.mn

2024.11.01 № 10-33-02/135/183

ТООНОТ КОНСТРАКШН ХХК-ИЙН
ЗАХИРАЛ А.БАТЦЭНГЭЛ ТАНАА

Барилгын зураг төсөл хянасан
тухай

Эрүүл ахуйн тухай хуулийн 5 дугаар зүйлийн 5.3. дахь "Барилга байгууламж барих газрын байршил тогтоох, барилгын зураг төсөл зохиох, барилга барих, ашиглалтад оруулах, өргөтгөх, зориулалтыг нь өөрчлөхөд холбогдох хяналтын байгууллагаар эрүүл ахуйн дүгнэлт гаргуулна." заалт, ЭМЯ-ны Салбарын хяналтын газрын 2024 оны 01 дүгээр сарын 05-ны өдрийн 10-00/02 дугаартай "Барилга байгууламж барих, газрын байршил тогтоох, барилгын зураг төсөл зохиох, барилга ашиглалтад оруулахад урьдчилан сэргийлэх хяналт, шалгалт хийх тухай" удирдамжийг үндэслэн "Тоонот констракшн" ХХК-ийн 2024 оны 10 дугаар сарын 15-ны өдрийн ТК/2024 дугаартай хүсэлтийн дагуу Хөвсгөл аймаг, Рашаант сумын 4-р багт баригдах Төрийн банк ХК-ийн тооцооны төвийн барилгын ТК-29/2024 шифрийн дугаартай ажлын зурагт аймгийн Эрүүл мэндийн газрын эрүүл ахуй, халдвар хамгааллын хяналтын улсын байцаагч Н.Дамбадаржаа 2024 оны 10 дугаар сарын 23-ны өдөр хүлээн авч, хяналт хийв.

Төрийн банканд сумын засаг даргын 2013 оны 11 дүгээр сарын 08-ны өдрийн А/88 дугаартай захирамжаар Рашаант сумын 4 дүгээр багт төв хэсэг-3 305 тоотод 6706000771 нэгж талбайн дугаартай 389 м.кв газрыг худалдаа, нийтийн үйлчилгээний газар, төв цогцолборын зориулалтаар олгосон байна.

Барилгын зураг төсөл нь аймгийн ерөнхий архитекторын 2024 оны 10 дугаар сарын 31-ний өдрийн АТД-67-0023/24 дугаартай архитектур төлөвлөлтийн даалгавар, 2023 оны 02 дугаар сарын 17-ны өдрийн зураг төсөл боловсруулах ажлын даалгавраар батлагдсан. Дулаан эрчим хүчээр хангах Мөнх хүслэнт-од ХХК-ийн 08 дугаартай, Цахилгаан эрчим хүчээр хангах ЭБЦТС ТӨХК-ийн Булган салбарын 2024 оны 04 дүгээр сарын 14-ний өдрийн 17/24 дугаартай техникийн нөхцөл тус тус олгогдсон байна.

Барилгын инженер геологийн "Инженер геодези" ХХК-ийн ЗТ11-132/22 шифрийн дугаартай 2024 оны 05 дугаар сарын 01-ний өдрөөс 07-ны өдрийн хооронд хийсэн инженер геологийн судалгааны дүгнэлтээр 6.0 метрийн гүнтэй 2 ширхэг цооног өрөмдөхөд судалгааны талбайд овоолтгүй инженер-геологийн 1 төрлийн эльмент илэрсэн, геоморфологийн нэг төрлийн элемент дээр байрладаг болон ул хөрсний ус илрээгүй зэргээс инженер-геологийн энгийн нөхцөлтэй талбайд хамаарна гэсэн байна.

Барилгын ерөнхий төлөвлөгөөнд нэг давхар тооцооны төв, бохир соруулах худаг, ногоон байгууламж, авто машины зогсоол, дугуйн зогсоол, амрах сандал зэргийг төлөвлөсөн байна.

Тооцооны төвийн барилга нь тэнхлэгээрээ 10.0 х 9.0 м хэмжээтэй зоорьгүй нэг давхар, баганан суурьтай, бүрэн цутгамал төмөр бетон араг бүтээцтэй, гадуур ус зайлуулах хоолойтой хавтгай дээвэртэй, барилгын цоколийн нь 200 мм зузаантай, М200 маркийн бетон, 100 мм шахмал полистрол хавтан дулаалга бүхий гадна ханатай, нэг давхарт 25.76 м.кв гүйлгээний танхим, 14.45 м.кв теллерийн хэсэг, 3.75 м.кв сейфний өрөө, 4.47 м.кв агуулах, 9.60 м.кв харилцааны менежерийн өрөө, 12.00 м.кв захирлын өрөө, 4.20 м.кв тусгай хэрэгцээт иргэдийн ариун цэврийн өрөө, 3.06 м.кв техникийн өрөө, 3.56 м.кв дулааны өрөө, 4.50 м.кв хөлийн өрөө, 5.04 м.кв гонх зэргийг зураг төсөлд төлөвлөсөн байна.

Халаалтын эх үүсвэр нь сумын төвийн нэгдсэн халаалтын системээс хангагдах ба халаалтын систем нь дээгүүр түгээлттэй хоёр хоолойт систем байхаар төлөвлөсөн байна.

Агаар сэлгэлтийн ердийн болон механик системтэй. Теллерийн хэсэгт агаар сорох механик систем, сейф, архивын өрөө, ариун цэврийн өрөө, щитьны өрөөнд агаар сорох ердийн систем төлөвлөсөн байна. Агаар дамжуулах хоолойнуудыг цайрдсан гөлмөн төмрөөр хийж, агаар сорох системийн хоолойнуудыг дээврээс дээш 0.7 м өндөрт гаргаж хоолойг дулаалахаар тусгасан байна.

Хүйтэн усны эх үүсвэр нь зөөврийн зөөврийн усан хангамжтай щитьны өрөөнд байрлах 150 л-ийн нөөцийн усны савнаас хангагдахаар төлөвлөгдсөн. Халуун ус нь ариун цэврийн өрөөнд суурилуулагдах агшин зуурын ус халаагчаар хангагдана. Бохир усыг ф50 мм голчтой 0.03 налуутай, ф100 мм голчтой 0.02 налуутай хуванцар хоолойнуудаар дамжин барилгаас өөрийн урсгалаар нэг гаргалгаагаар зайлуулагдан бохир усны худагт холбогдохоор төлөвлөгдсөн байна.

Зураг төслийг хянаад ДҮГНЭХ НЬ:

1.Барилгын ажлын зураг нь халаалт, агаар сэлгэлт ба кондиционер БНбД 41-01-11, Олон нийт иргэний барилга БНбД 31-03-03 норм, дүрмийн эрүүл ахуйн заалтын шаардлагыг хангаж байна.

2.Улсын байцаагчийн дүгнэлтийг эс зөвшөөрвөл Монгол улсын Төрийн хяналт шалгалтын тухай хуулийн 14 дүгээр зүйлийн 14.1-д заасны дагуу гомдол гаргах эрхтэй.

ДҮГНЭЛТ БИЧСЭН:
ЭРҮҮЛ АХУЙ, ХАЛДВАР ХАМГААЛЛЫН
ХЯНАЛТЫН УЛСЫН БАЙЦААГЧ Д.Дамбадаржаа Н. ДАМБАДАРЖАА

ТАНИЛЦАЖ ХҮЛЭЭН АВСАН: .....